

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Намсрайн Даваа	Дугаар	L064
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Хөлөнбуйр сум
Төрсөн газар	Хөлөнбуйр сум	Төрсөн он	1923
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Эрдэнэ гүний хийд	Сүм хийдийн дугаар	ХЭНЛ 101
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 21	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Норовлин сумын Эрдэнэ гүний хийд

-Эрдэнэ гүний хийдийн тухай та өөрийн санаж байгаа зүйлээс хэлж өгнө үү? Хийд хэдэн ламтай байсан бэ?

Эрдэнэ гүний хийдэд лав 500 орчим лам байсан. Байнга суудаг байсан байх. Том хүрээгээр лам нар нь суудаг байсан. Том том лам нартай байсан.

-Хурлын талаар?

Цам майдартай, тогтмол хурлуудтай байсан байх. Манай нэг ах лам байсан. Гавж байсан. Унзад ч хийж байсан, гэсгүй ч хийж байсан. 1937 онд баригдаад явсан. Нас барсан.

-Хийдийн сахиус шүтээний талаар?

Тэрийг мэдэхгүй.

-Хэдэн дугантай байсан?

Цогчэн, Чойр гэсэн дуган л лав байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Хийд хаана хаана байрлаж байсан бэ?

Ердөө энүүхэнд Бор хавцгай гэж байсан. Тэнд байсан. Тэрнээсээ нүүгээд Түмэн хан гэдэг уулын хойно нэг буусан. Тэндээсээ зүүн тийш нэг буусан. Тэгээд тэндээсээ эргэж нүүгээд Хараатын голын тэнд буусан.

-Байгуулагдсан он цагийн тухайд?

Их л эрт байх. Эрдэнэ гүн байгуулсан байх.

-Хийдийн миндагтан лам нарын нэрийг санаж байна уу?

Одоо мартчаад байна аа. Ёндон зурхайч гэж нэг мэргэн хүн байсан. Ширээт ламын нэр хэн билээ? Тушаалаар нь нэрлэдэг байсан болохоор нэрийг нь хэлдэггүй байсан. Ёндон зурхайч учиргүй нэртэй нь ч юу юм бэ гэхдээ хүмүүс их шүтдэг байсан.

- Хийдэд ном бүтээл туурвидаг тийм лам нар эрдэмтэй хүмүүс байсан болов уу?

Тэрийг сайн мэдэхгүй байна.

-Хэдэн онд хаагдсан бэ?

1937 онд хаагдсан.

-Лам нар баригдахаас өмнө дуганыг хаасан уу? Дуган хаагдаад лам нар баригдсан уу?

Тэр үед би 15, 16-тай л хүүхэд байсан. Залуувтар барагтай лам нар нь хар болсон. Ихэнх нь баригдаад явсан. Дуган нь хураагдсан. Дуганыг буулгаад мод энэ тэр нь артель л байшин барилгархуу юм болгосон байх. Тэр суурины баруун урд, баруун хойно нь хоёр худаг байсан. Дүүрэн ном, бурхан хийчихсэн байсан гэсэн. Сүүлд нь энэ Роломынхон баруун хойт худгаас ном, бурхан гаргаж авсан гэж сонссон. Мөн геологийнхон ч бас гаргаж авлаа гэж дуулдаж байсан.

-Саруул гүний хийдийн талаар?

Саруул гүний хийдийн тухай Майдар, Цам л гэж мэдэхээс өөр юм мэдэхгүй. Тэнд нь очиж байсан.

-Хэдэн дугантай байсан бол?

Саруул гүний хийд манай хийдийг бодоход бага байсан. Нэг дугантай байсан. Голын урд Тугийн дуган гэж байсан. Нэг дуган.Хаалгаар ороод очуут Чингисийн баатрууд сэлмээ шар хийтэл далайдаг. Их сүрдмээр. Би багадаа нэг ороод буцаж зугтааж байсан юм.

-Цорж ламын хийд гэж дуулсан уу?

Тэрийг сайн мэдэхгүй байна.